


# Төгс эзэмших сургаалаар дамжуулан сүнслэг инерцийг олж авах нь



Дугуй унаж буй хүн нь та, харин зам нь таны амьдралыг төлөөлж байна гээд төсөөл. Замын тань эхний хэсэг хэрхэн шулуун байгааг та анзаарч магадгүй юм. Гэхдээ цаашид даван туулахын тулд илүү их хүчин чармайлт шаардах саад бэрхшээл, налуутай та тулгарах болно. Амьдралыг амжилттай даван туулахын тулд танд хэрэгтэй сүнслэг инерц, тулгарч болох саад бэрхшээл, сорилтуудын талаар бод.

Суралцаж буй төгс эзэмших сургаалын түлхүүр үг хэллэгүүдийг судалж, таны хувийн замналтай холбоотой хэсгүүдийг хайж ол. Зурган дээрх харгалзах тоонуудын хажууд танд тусалж болох төгс эзэмших сургаалын хэсгийн эшлэлийг бич.

1. Өдөр бүр сүнслэг инерц, ахиц дэвшлийг хадгал.
2. Эшлэлд заасан үнэний дагуу итгэж, үйлдэх үедээ саад бэрхшээлээс зайлсхий эсвэл түүнийг даван туул.
3. Сүнслэг зорилгодоо хүрэхийн тулд Аврагчийн хүч чадалд тулгуурлан, өөдөө бос.

Зурсан зургаа оруулаад, өөрийн сонгосон төгс эзэмших сургаалын хэсэг бүрд дараах санаануудын дор хаяж нэгийг нь талаар бодол санаагаа бичиж тэмдэглэ.

- Төгс эзэмших сургаалын хэсэг дэх үнэнийг болон ач холбогдлыг мэдэрсэн таны туршлага.
- Та уг хэсгийн сургаалыг эсвэл зарчмыг амьдралдаа илүү сайн хэрэгжүүлэхийн тулд юу хийж чадах вэ?
- Яагаад энэхүү хэсэг таныг Аврагчийн хүчээр адисалж, сүнслэг инерцийг тань нэмэгдүүлнэ гэж та бодож байна вэ?
- Сургаал нь Тэнгэрлэг Эцэгийг болон Есүс Христийг хайрлах таны хайрыг хэрхэн нэмэгдүүлсэн бэ?